



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2014 оны 09 сарын 27 өдөр

Дугаар #1458

Арвайхээр

Албан тушаалын тодорхойлолт  
батлах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29,2 дахь хэсэг, Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 03 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтаар баталсан "Албан тушаалын тодорхойлолт боловсруулах нийтлэг журам"-ын 5.3, 6.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

- 1.Өвөрхангай аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын харьяа Сум дундын Ойн ангийн даргын албан тушаалын тодорхойлолтыг хавсралтаар баталсугай.
- 2.Батлагдсан албан тушаалын тодорхойлолтыг албан тушаалд томилогдож буй этгээдэд албан ёсоор танилцуулж, хувийн хэрэгт хавсаргахыг аймгийн Засаг даргын дэргэдэх Байгаль орчин, аялал жуулчлалын газар (Г.Баясгалан)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

А.ИШДОРЖ



011100969

D:My Doc. Zahiramj. Zasag darga

## АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

### I. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан үндэслэл:

- Төрийн албаны тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан  
шинэчлэн боловсруулсан
- Хууль тогтоомжоор байгууллагын чиг үүрэгт өөрчлөлт орсон  
Холбогдох хууль тогтоомжийн нэр, огноо:

Дагаж мөрдөх огноо:

Албан тушаалын тодорхойлолтыг  
баталсан огноо:

Байгууллагын нэр:

Өвөрхангай аймгийн Байгаль орчин,  
аялал жуулчлалын газрын харьяа  
“Сум дундын Ойн анги” орон нутгийн  
аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар

Нэгжийн нэр:

Албан тушаалын нэр:

Ойн ангийн дарга

ТҮ-9

Ажлын цаг:

Ажлын өдөр 8 цаг

Албан тушаалын ангилал, зэрэглэл:

Монгол улс, Өвөрхангай аймаг, Бат-өлзий  
сум, Сум дундын Ойн анги

Хөдөлмөрийн нөхцөл:

Хэвийн

Онцгой нөхцөл:

Хамаарахгүй

### II. АЛБАН ТУШААЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ЧИГ ҮҮРЭГ

Албан тушаалын зорилго

Байгаль орчны салбарын хууль тогтоомж, тогтоол шийдвэр, бодлогын баримт бичгүүдэд  
ойн чиглэлээр тусгагдсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэх, сум дундын Ойн ангийг өдөр  
тутмын удирдлагаар хангаж, ажлын гүйцэтгэлийн үр дүнг Аймгийн Засаг дарга болон

Байгаль орчин, аялал жуулчлалын газрын даргын өмнө хариуцна.



Албан тушаалын зорилт:


- Ойн салбарын хууль тогтоомж, тогтоол шийдвэр, бодлогын баримт бичгүүдэд ойн чиглэлээр тусгагдсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэх
- Ойжуулалт, ойг нөхөн сэргээх, зүй зохистой ашиглах, менежментийг сайжруулах, боловсронгуй болгох, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулах, ойжуулалт, ойг нөхөн сэргээх чиглэлээр хуваарилсан арга хэмжээг гүйцэтгэх, тайлагнах
- Ой, цөлжилтийн талаар мэдээллийн сан бүрдүүлж хэрэглэгчдийг мэдээллээр хангах, иргэдийн экологийн боловсролыг дээшлүүлэх, ой бүхий сумдын ойн нөхөрлөл, мэргэжлийн байгууллагуудыг мэргэшлийн удирдлагаар хангах, чадавхжуулах
- Төсвийн шууд захирагчийн хувьд байгууллагын төсвийн хөрөнгийг удирдах, батлагдсан төсвийг зориулалтын дагуу үр ашигтай захиран зарцуулах, тайлагнах
- Байгууллагын үйл ажиллагааг удирдан зохион байгуулах
- Хууль тогтоомжид заасан бусад чиг үүргийг хэрэгжүүлэх

Зорилт	Албан тушаалын гүйцэтгэх чиг үүрэг	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хариуцлага, оролцооны хэлбэр Туслах - Т, Хариуцан гүйцэтгэх - Г Хянах - Х Шийдвэрлэх - Ш
1 дүгээр зорилтын хүрээнд	<ol style="list-style-type: none"> <li>Ойн салбарын хууль тогтоомж, тогтоол шийдвэр, бодлогын баримт бичгүүдийн хэрэгжилтийг хангах, тайлагнах;</li> <li>Ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах, хяналт тавих;</li> <li>Байгаль орчныг хамгаалах тухай хууль болон Ойн тухай хууль, ой түүний дагалт баялаг, биологийн төрөл зүйлийг тогтвортой ашиглах, хамгаалах, нөхөн сэргээх талаар хууль тогтоомжид заасан үүргээ гүйцэтгэхэд нь сумын Засаг даргад мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх;</li> </ol>	<p>Ой хамгаалах, түүний нөөц баялагийг зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх талаарх төрийн бодлого шийдвэр хэрэгжсэн байна.</p> <p>Ой хээрийн түймэр гараагүй байх</p> <p>Мэргэжил арга зүйн зөвлөгөөгөөр хангаж ажилласан байна.</p>	Г, Х
2 дугаар зорилтын хүрээнд	<ol style="list-style-type: none"> <li>Ойн хөнөөлт шавжийн устгал, тэмцэл явуулах, голомт тархалтын судалгаа хийлгэх ажлыг зохион байгуулах, хэрэгжүүлэх;</li> <li>Хууль бус мод бэлтгэлийг таслан зогсоох, урьдчилан</li> </ol>	<p>Ойн хөнөөлт шавжийн тандалт судалгааг жил бүр хийлгэж устгал тэмцлийн ажлыг зохион байгуулна.</p> <p>Хууль бус мод бэлтгэл</p>	Г, Х

	<p>сэргийлэх ажлыг удирдан зохион байгуулах, хяналт тавих;</p> <p>3. Ойн нөөцийг нөхөн сэргээх арга хэмжээг хэрэгжүүлэх улс, орон нутгийн захиалгат ажлын хэрэгжилтийг зохион байгуулах;</p> <p>4. Модны үр. тарьц бэлтгэх ажлыг зохион байгуулах, мод үржүүлгийн газрын үйл ажиллагаа эрхлэх, тарьц суулгац худалдаалах;</p> <p>5. Ойн сангаас бэлтгэж байгаа модон материалд гарал үүслийн гэрчилгээ, эрхийн бичиг олгох, мод бэлтгэх гэрээ байгуулах, дагалт баялаг, ургамал амьтны гаралтай түүхий эдийн ашиглалт, борлуулалтад хяналт тавих;</p> <p>6. Ой ашиглалт, мод бэлтгэлийн ажлын явцад технологийн хяналт тавих, удирдлага зохицуулалтаар хангах;</p> <p>7. Ой зохион байгуулалтын материалыг үндэслэн нөхөрлөл аж ахуйн нэгжийн менежментийн төлөвлөгөө боловсруулах, зөвлөлгөө өгөх</p>	<p>буурсан байна.</p> <p>Ойн нөөцийг хамгаалах арга хэмжээг удирдан зохион байгуулна.</p> <p>Тарьц суулгацны нөөцийг бүрдүүлж, бодлого зохицуулалтаар хангаж ажилласан байх.</p> <p>Ойн нөөц ашигласны төлбөрийн орлогыг бүрдүүлэхэд хяналт тавин ажилласан байх.</p> <p>Мод бэлтгэлийн үйл ажиллагаанд хяналт тавих</p> <p>Менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтэнд хяналт тавих ажилласан байна.</p>	 <p>Г, Х</p> <p>Г, Х</p> <p>Г, Х</p> <p>Г, Х</p>
3 дугаар зорилтын хүрээнд	<p>1. Ойн сангийн мэдээ, тайлан, судалгаа гаргах, мэдээллийн сан бүрдүүлж, баяжилтыг тухай бүр хийх;</p> <p>2. Ойн нөхөрлөл, мэргэжлийн байгууллагуудыг мэргэшлийн удирдлагаар хангаж, чадавхжуулах;</p> <p>3. Ойн чиглэлээр нөхөрлөл, мэргэжлийн байгууллага, иргэдийн экологийн боловсролыг дээшлүүлэх сургалт сурталчилгааны ажлыг зохион байгуулах;</p> <p>4. Ойн хөнөөлт шавьж, өвчний голомтын тойм судалгаа хийж дүгнэлт гаргах, ойн төлөв байдалд үнэлгээ өгөх, ойн тооллого, бүртгэл, зохион байгуулалт, хөнөөлт шавьж, өвчний тэмцлийн</p>	<p>Мэдээ тайланг тогтоосон хугацаанд гаргаж холбогдох газруудад тайлагнасан байна.</p> <p>Нөхөрлөл аж ахуйны нэгжүүдийг удирдлага зохион байгуулалтаар хангаж ажилласан байна.</p> <p>Иргэдийн ухамсар дээшилж, хандлага өөрчлөгдсөн байх.</p> <p>Ойн хортоны судалгааг мэргэжлийн байгууллагаар хийлгүүлж, устгалын ажлыг зохион байгуулах, ой зохион байгуулалт, тооллогын ажил хийгдсэн байна.</p>	<p>Г</p> <p>Г</p> <p>Г</p> <p>Г, Х</p>



	ажлын явцад хяналт шинжилгээ хийх.		
4 дүгээр зорилтын хүрээнд	<ol style="list-style-type: none"> <li>Байгууллагын зорилт, чиг үүргийг хэрэгжүүлэхэд шаардагдах төсөв, санхүү, бусад нөөцийн талаар санал, төсвийн төсөл боловсруулж, батлуулах;</li> <li>Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулж, хяналт тавих, үр дүнг дээшлүүлэх, гүйцэтгэлийг тайлагнах;</li> <li>Төрийн болон орон нутгийн өмчийн ашиглалт, эзэмшилтэд хяналт тавьж балансад байгаа өмч хөрөнгийг зохих журмын дагуу эзэмшиж ашиглах;</li> <li>Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлэх, тайлагналтад хяналт тавих;</li> <li>Төсөв санхүүгийн болон худалдан авах үйл ажиллагааны ил тод байдлыг хангах.</li> </ol>	Төсвийн шууд захирагчийн чиг үүргийг хууль тогтоомжид заасны дагуу хэрэгжүүлсэн байна.	Г Х Х
5 дугаар зорилтын хүрээнд	<ol style="list-style-type: none"> <li>Сум дундын Ойн ангийн даргын аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга болон аймгийн Засаг даргатай, гурвалсан гэрээ байгуулан ажиллах;</li> <li>Байгууллагын дотоод дүрэм, журам, гүйцэтгэлийн төлөвлөгөөг батлуулж хэрэгжилтийг хангуулах;</li> <li>Холбогдох төрийн байгууллагаас баталсан бүтэц, зохион байгуулалтын хүрээнд ажилтнуудын албан тушаалын тодорхойлолтыг батлах, ажилтныг ажилд томилох, чөлөөлөх, тэдэнтэй хөдөлмөрийн гэрээ байгуулах;</li> </ol>	Гэрээний үүргийн биелэлтийг хэрэгжилтийг ханган ажилласан байна.  Дүрэм журмын хэрэгжилтийг ханган ажилласан байх	Г Г
6 дугаар зорилтын хүрээнд	<ol style="list-style-type: none"> <li>Албан тушаалтын хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө орлогын мэдүүлгийг хуульд заасан хугацаанд үнэн зөв гаргах, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид</li> </ol>	ХАСХОМ-ийг хуулийн хугацаанд үнэн зөв гаргаж өгсөн байна.	Г

	<p>байх;</p> <p>2. Төрийн албан хаагчийн ёс зүй, сахилга хариуцлагатай холбогдох дүрэм, журмыг чанд мөрдөн ажиллах;</p> <p>3. Хариуцсан ажлын чиглэлээр ирсэн албан бичиг, өргөдөл, гомдлыг шийдвэрлэх;</p> <p>4. Хууль тогтоомжид заасан бусад чиг үүргийг хэрэгжүүлэх ажлын гүйцэтгэл, үр дүнг Байгаль орчин, аялал жуулчлалын газрын даргын өмнө хариуцан ажиллах.</p>	<p>Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилгүй ажилласан байна.</p> <p>Ирсэн бичиг, өргөдөл, гомдол шийдвэрлүүлсэн байдлаар</p> <p>Үүрэг даалгаврын биелэлтээр</p>	 Г,Х
--	---	--	---

### III.АЛБАН ТУШААЛД ТАВИГДАХ ТУСГАЙ ШААРДЛАГА

Боловсрол	Бакалавр болон түүнээс дээш боловсролын зэрэгтэй.		
Мэргэжил	Ойн аж ахуй /082/, мод боловсруулах /072203/,		
Мэргэшил	-		
Туршлага	Мэргэжлээрээ 4-өөс доошгүй жил ажилласан байх.		
Ур чадвар	Удирдан зохион байгуулах	<ul style="list-style-type: none"> <li>- шинэ санал, санаачилга, бүтээлч хандлагатай байх;</li> <li>- төрийн албан хаагчийн ёс зүй, хэм хэмжээг сахих;</li> <li>- хариуцсан ажлаа төлөвлөх, зохион байгуулах;</li> <li>- албан хаагчдын ажлын үүргийг оновчтой хуваарилж, удирдан зохион байгуулах;</li> <li>- албан хаагчдын ажлын гүйцэтгэлд хяналт тавьж, өдөр тутмын удирдлагаар хангах;</li> <li>- хариуцсан нэгжийн үйл ажиллагааг зохион байгуулж, гүйцэтгэлийг дүгнэж, шаардлага тавьж чаддаг байх;</li> <li>- бусад.</li> </ul>	
	Дүн шинжилгээ хийх	<ul style="list-style-type: none"> <li>- албан ажлын хэрэгцээнд шаардагдах мэдээлэл цуглуулах, боловсруулах, харьцуулалт хийх, нэгтгэж дүгнэх, санал, зөвлөмж боловсруулах;</li> <li>- гүйцэтгэж буй ажлын явц, үр дүнг тайлагнах;</li> <li>- судалгааны ерөнхий арга зүйн мэдлэгтэй байх;</li> <li>- тоон мэдээлэлтэй ажиллах, нэгтгэн дүгнэх, статистикийн арга хэрэгслийг ашиглах чадвартай байх;</li> <li>- бусад.</li> </ul>	
	Асуудал шийдвэрлэх	<ul style="list-style-type: none"> <li>- үндэсний язгуур эрх ашиг, сонирхолд захирагдан, ард түмэндээ үйлчилж, төрд үнэнчээр зүтгэх;</li> <li>- хууль тогтоомжийн хурээнд асуудлыг шийдвэрлэх</li> </ul>	




	<ul style="list-style-type: none"> <li>- хувилбарыг боловсруулах;</li> <li>- шинэчлэл өөрчлөлт хийхийг зорьдог байх;</li> <li>- аливаа үйл ажиллагааны үр дүн, үр нөлөөг урьдчилан харах чадвартай байх;</li> <li>- албан үүргээ ёс зүйн зарчимд нийцүүлэн, ашиг сонирхлын зөрчлөөс ангид шийдвэрлэх;</li> <li>- хууль, эрх зүйн үндэслэл бүхий зөвлөгөө өгөх чадвартай байх;</li> <li>- бүтээлч, санаачлагатай ажиллах;</li> <li>- бусад.</li> </ul>
Манлайлах	<ul style="list-style-type: none"> <li>- төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг сахих;</li> <li>- шинэ санаачилга, бүтээлч байдлыг эрхэмлэх;</li> <li>- өөрийн мэдлэг чадвар, өөрт байгаа мэдээллийг баг хамт олонтой хуваалцаж, бие биеэ дэмждэг байх;</li> <li>- багийн хамт олны дунд хүлээсэн үүргээ гүйцэтгэх;</li> <li>- багийн зорилго, үйл ажиллагааг ойлгож, дасан зохицож ажиллах;</li> <li>- үл ойлголцлыг эв зүйгээр зохицуулах;</li> <li>- хамт олонч сэтгэлгээтэй, эерэг уур амьсгалыг дэмждэг байх;</li> <li>- нээлттэй шударга байх;</li> <li>- бусад.</li> </ul>
Бусад	<ul style="list-style-type: none"> <li>- албан ажлын чиг үүргийнхээ дагуу зөвлөгөө мэдээллээр хангаж ажиллах чадвартай байх;</li> <li>- компьютерын хэрэглээний программ, мэдээллийн дэвшилтэт технологи ашиглах;</li> <li>- төрийн албан хэрэг хөтлөлт, бичиг хэрэг, монгол хэл, найруулга зүйн чадвартай байх;</li> </ul>

#### IV.АЛБАН ТУШААЛТНЫ ХАРИЛЦАХ СУБЬЕКТ

Албан тушаалыг шууд харьялан удирдах албан тушаалын нэр:

Аймгийн Засаг дарга

<u>Албан тушаалд шууд харьялан удирдуулах албан тушаалын нэр, тоо:</u>	<u>Бусад харилцах субъект :</u>
<ul style="list-style-type: none"> <li>- Нягтлан бодогч-1</li> <li>- Ойн инженер-2</li> <li>- Ойн техникч-1</li> <li>- Сахиул-1</li> <li>- Гэрээт ажилтнууд</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- салбарын яам, агентлагийн холбогдох мэргэжилтэн</li> <li>- аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга, ойн нэгжийн дарга, мэргэжилтийн</li> <li>- сумын ИТХурал</li> <li>- сумын Засаг дарга</li> <li>- салбарын байгууллагууд,</li> <li>- ой хамгаалах нөхөрлөл, мэргэжлийн</li> </ul>

	<p>байгууллагууд,</p> <ul style="list-style-type: none"> <li>- сумдын байгаль хамгаалагчид</li> <li>- идэвхтэн байгаль хамгаалагчид</li> <li>- иргэн, хуулийн этгээд.</li> </ul>
<b>V.АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫН БАТАЛГААЖУУЛАЛТ</b>	
<u>Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан:</u>	<u>Албан тушаалын тодорхойлолтыг хянаж, батлах зөвшөөрөл олгосон байгууллагын шийдвэр:</u>
<u>Албан тушаал:</u>  БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТ, ХҮНИЙ НӨӨЦ, ДОТООД АЖИЛ ХАРИУЦСАН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН   Э.ЗОЛЗАЯА 20.... оны ..... дугаар сарын .....-ны өдөр	<u>Байгууллагын нэр:</u>  Аймгийн Засаг даргын захирамж Шийдвэрийн огноо:..... Дугаар:.....
<u>Албан тушаалын тодорхойлолтыг баталсан:</u>	
<u>Байгууллагын нэр:</u> <b>ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР</b> Шийдвэрийн огноо: <u>2021.09.24</u> Дугаар: <u>A/459</u>  (тамга/тэмдэг)	
ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА  <u>2021 оны 09 дугаар сарын 27-ны өдөр</u>  А.ИШДОРЖ	

